09

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 24 өдөр Дугаар 7/29 Номгон

Ковидын дараах иргэдийн эрүүл мэндийг
сайжруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг,
эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж", Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус YII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Ковидын дараах иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д ДААЛГАХ нь:

2.1. Төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган чанартай зохион байгуулж, хяналт тавьж ажилласугай.

2.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны IY улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

0121070

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус
VII хуралдааны 7/29 дүгээр тогтоолын хавсралт

## КОВИДЫН ДАРААХ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ЭРТ ИЛРҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хариуцах эзэн, хамтран ажиллах | Хугацаа | Үр дүн | Төсвийн эх үүсвэр | Төсөв /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 1.1 | Стандартын дагуу тохижуулсан өрөө байрны асуудлыг шийдвэрлүүлэх /БЗДХкабинет, СДЗШӨкабинет, Өсвөр үеийн кабинет/ | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 он | Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үзлэгийн чанар, өвчний илрүүлэлт сайжирна. | Орон нутгийн төсөв | Барилгын их засварын зураг төслийн төсөв тооцсоноор |
| 1.2 | Сайн дурын зөвлөгөө шинжилгээ өгөх кабинетийг 2 зах дээр байршуулах түрээслэх байрыг шийдвэрлүүлэх | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 оны 1-р улиралд | Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үзлэгийн чанар, өвчний илрүүлэлт сайжирна. | Орон нутгийн төсөв | 1 сард 2 байр 600,0 мян.төгрөг, Жилд 7.2 сая.төг |
| 1.3 | БЗДХ-ийн кабинетийн 3 эмчийг тус бүр суух өрөө, үзлэгийн өрөөтэй болгох | Нэгдсэн эмнэлэг | 2022 оны 1 сард | Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин бүрдэж, сэтгэл ханамж бүрдэнэ | НЭ-ийн төсөв | Эмч нарын цалин, урамшуулал |
| 1.4 | Өсвөр үеийн кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллуулах /Хуучин байранд/ | Нэгдсэн эмнэлэг | 2021 оны 1-р улиралд | Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин бүрдэж, сэтгэл ханамж бүрдэнэ | НЭ | Эмч, зөвлөгчийн цалин, засварын зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Жирэмсэн болон төрөх насны эмэгтэйчүүдийг үзэх дотрын эмчийг томилж ажиллуулах | Нэгдсэн эмнэлэг | 2021 оны 12-р улиралд | Жирэмсэн болон төрөх насны эмэгтэйчүүдийн эрт хугацаанд оношлогдоно. | НЭ | Эмчийн цалин, урамшуулал |
| 1.6 | Бүх байгууллагын шийдвэр гаргагч, удирдлагуудад нөлөөллийн уулзалт, сургалт зохион байгуулах | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ТББ | 2022 оны 1 дүгээр сар | БЗДХ бууруулахад хүн бүрийн оролцоо нэмэгдэж, БЗДХ-ын талаар нэгдсэн ойлголттой болно | ДЭМБ | 13 500,000 төгрөг |
| 1.7 | 100 хувь бэлгэвч төслийг хэрэгжүүлэх, Бэлгэвчний автомат машин /Олон улсын төсөл хөтөлбөр, ТББ/ | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022-2024 он | Хүн амын дундах БЗДХ-ын эрсдэл буурна | Орон нутгийн төсөв | 2ш-5.0 сая.төгрөг /Бэлгэвчний автомат машин/ |
| **ХОЁР.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 2.1 | БЗДХ/ХДХВ/ДОХ-ийн төрөлжсөн мэргэжлийн эмч 1-2 бэлтгэх | ЭМГ, НЭ | 2022 он | Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчээр хангагдана. | ЭМГ | Төрийн сангийн зардлаар сургах |
| 2.2 | Серологич эмч бэлтгэх | ЭМГ, НЭ, ХӨСҮТ | 2022оны эхний хагас жилд | Шинжилгээнд хяналт тавьж оношийн зөрүү гарахгүй болно | ЭМГ | Төрийн сангийн зардлаар сургах |
| 2.3 | ЭМС-ын 2017 оны 8 сарын 3-ны А/305 тоот тушаалын дагуу БЗДХ-ын кабинетийг орон тоогоор нь ажиллуулах | НЭ | 2021 оны 12 сараас | Бүтэц орон тоогоор ажиллаж ажлын ачаалал буурч, ажлын бүтээмж нэмэгдэнэ | НЭ | НЭ-ийн Цалингийн сангаас мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор |
| 2.4 | Эмч, лаборант нарыг чадавхжуулах сургалт /мини ПСР/ | ЭМГ, НЭ | 2022 оны 1 сард | 35 оролцогч, 2 өдөрт сургасан байна | ДЭМБ | 6 000.0 |
| **ГУРАВ.ЛАБОРАТОРИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР** | | | | | | |
| 3.1 | ХӨСҮТөвд серологи лаборант нарыг ажлын байрны богино хугацааны сургалтанд хамруулах | ХӨСҮТ, ЭМГ, НЭ | Жилд 1 удаа | Мэдлэг мэргэжил дээшилнэ, шинжилгээ хийх чавдар сайжирна | Нэгдсэн эмнэлэг | Замын зардал Томилолт, сургалтын төлбөр 5 хоног |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | Молекул биологийн лабораторт БЗДХ-ын PCR шинжилгээ хийхэд шаардлагатай урвалж оношлуураар хангах | Нэгдсэн эмнэлэг | 2 улиралд | БЗДХ-ын 17 төрлийн өвчлөлийг илрүүлж эмчлэн эрүүлжүүлнэ. Иргэдийн чирэгдэл буурна | Нэгдсэн эмнэлэг | Нэгдсэн эмнэлгийн эмийн төсөвөөс |
| 3.3 | ДОХ, Тэмбүүгийн түргэвчилсэн тестийг нийлүүлэгч компаниудаас монгол заавартай гаргаж ӨЭМТ, СЭМТ-ийг хангаж өгөх | ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 1 улиралд | Зааврын дагуу зөв хийж хэвших, алдаагүй зөв оношилно | ЭМГ | Тендэрийн татан авалтаар |
| 3.4 | Төрөлхийн тэмбүү болон тэмбүүгийн шинэ хуучныг ялган оношлох Иммуноглобулин М, G үздэг элиза аппарат болон оношлуураар хангаж өгөх | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 оны 1 дүгээр улиралд | Оношилгооны ач холбогдолтой | Орон нутгийн төсөв | Элиза аппарат-13.0 сая.төгрөг /Цаашид оношлуурыг НЭ хариуцна./ |
| 3.5 | ХӨСҮТ-д гадаад хяналтаа лаборант нар өөрсдөө аваачиж өгөөд хариугаа авч ирдэг болох | Нэгдсэн эмнэлэг | 2022 он | Оношийн зөрүү арилна | Нэгдсэн эмнэлэг | Нэгдсэн эмнэлгийн төсөв |
| 3.6 | Мини ПСР аппарат эрүүл мэндийн анхан шатны 25 нэгжид нийлүүлэх | ЭМГ | 2022 оны 1 дүгээр сард | Лабораторийн оношлогооны хүчин чадал сайжирсан байна | УИХДарга ЭМ-ийн Зөвлөхийн хандив | 370 000.0 |
| 3.7 | Мини ПСР-ын оношлуур | ЭМГ | 2022 оны 1 дүгээр сард | Оношилгооны чадвар сайжирч, илрүүлэлт чанаржина | УИХДарга ЭМ-ийн Зөвлөхийн хандив | 9 600.0 |
| **ДӨРӨВ.ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 4.1 | Жирэмсний хяналтад орж байгаа жирэмсэн эхийг нөхөр болон хамтран амьдрагч хамт БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулах | ЭМГ, НЭ, сум дундын эмнэлэг, сум ӨЭМТ | 2022 оны 1 дүгээр улиралд | БЗДХ-ын илрүүлэлт сайжирна. | Нэгдсэн эмнэлэг | Эмнэлгийн ажилтны цалин, урамшуулал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | Аймгийн хэмжээнд 15-64 насны зорилтот бүлгийн иргэдийг БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулах бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан аян зохион байгуулах /Сүрьеэ/ | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 он | Зорилтот насны иргэдийн БЗДХ-ын өвчнийг эрт хугацаанд илрүүлж үр дүнг тооцно | Орон нутгийн төсөв | 289 990.0 |
| 4.3 | Сум,өрхийн эмнэлгүүд зорилтот хүн амынхаа нэрсийг гаргах | ӨЭМТ, СЭМТ | 2022 оны 1 дүгээр улиралд | Аяны бэлтгэл ажил хангагдана | ЭМГ | Цалин урамшуулал |
| 4.4 | Үзлэгийн явц, үр дүнг хянах бичил программтай болох | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн ID инженерүүд | 2022 оны 1 дүгээр улиралд | Нэгдсэн системтэй болсоноор хяналт сайжирна | Орон нутгийн төсөв | 7 000.0 |
| 4.5 | Жолооны курс, Үйлчилгээний ажилчид, түр саатуулах байранд саатуулагдаж байгаа иргэд, цэргийн бүртгэлд бүртгүүлж байгаа хүмүүс, автын үзлэгт оруулж байгаа жолооч нарыг БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулдаг болох, БЗДХ-ын эмчээр гарын үсэг зуруулдаг болохыг нэгдсэн журмаар зохион байгуулж тогтмолжуулах | Төрийн болон төрийн бус байгууллагууд | Жилийн турш | БЗДХ-ын үзлэг шинжилгээнд урьдчилан хамруулсанаар тухайн үйлчилгээг үзүүлдэг болох, БЗДХ-ын ирүүлэлт сайжирна | Нэгдсэн эмнэлэг | Тохиолдлын тоогоор ЭМД-аас санхүүжинэ |
| 4.6 | Үзлэгийн явуулын баг ажиллуулах /Дотор, мэдрэл, сүрьеэ, хүүхэд, Дүрс оношлогоо, Эмэгтэйчүүд, БЗДХ эмч, техникч, сувилагч-10 хүн | Төрийн болон төрийн бус Эрүүл мэндийн байгууллагууд | Жилд 1 удаа | Хуваарийн дагуу сумдуудад ажиллаж, БЗДХ-ын өвчлөлийг эрт илрүүлж, эмчилнэ | Нэгдсэн эмнэлэг | 80 000.0 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 4.7 | Хөдөлгөөнт хүн ам, өртөмтгий бүлгийн хүн ам, өсвөр үеийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж илэрсэн өвчлөлийг эрүүлжүүлэх | Төрийн болон төрийн бус Эрүүл мэндийн байгууллагууд | Жилийн турш | Өвчлөлийг эрт илрүүлж эмчлэн эрүүлжүүлнэ | Нэгдсэн эмнэлэг | Тохиолдлын тоогоор ЭМД-аас санхүүжинэ |
| 4.8 | Хавьтлыг сар бүр дуудаж үзлэг, шинжилгээнд хамруулж, хяналт тавих | Нэгдсэн эмнэлэг | Жилийн турш | БЗДХ буурна | Нэгдсэн эмнэлэг | Сар тутам 10литр бензин |
| 4.9 | Бэлэн байдлын ХХХ-ын нөөц бүрдүүлэх | ЭМГ | 2022 оны эхний улирал | Ковидын дэгдэлтийн үед хамгаалах хувцасны нөөц хангагдсан байна | Засаг даргын нөөцөөс | 300 000.0 |
| **ТАВ.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХАНГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 5.1 | Албан хэрэгцээ, сургалт сурталчилгааны өрөөний тохижилт | ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 он | Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүнэ, ажилчдын ажиллах орчин сайжирч, ажлын бүтээмж дээшилнэ | | 24 650.0 |
| 5.2 | Үзлэг шинжилгээний өрөөний тохижилт | ЗДТГ, ЭМГ, НЭ | 2022 он | Оношилгооны чанар сайжирна | | 15 300.0 |
| **ЗУРГАА.МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 6.1 | Зорилтот бүлэгт чиглэсэн сургалт хийх | ЭМБ-ууд | 1 сар бүр | Иргэдийн бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг хандлага сайжирна | Хөтөлбөрийн зардлаас | |
| 6.2 | Орон нутгийн телевизороор бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн цаг нэвтрүүлэг тогтмол явуулах | ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | Тогтмол | Иргэдийн бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг хандлага сайжирна | Хөтөлбөрийн зардал | 5 000 .0 |
| 6.3 | Орон нутгийн сурталчилгааны самбаруудыг ашиглаж бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдээлэл, сурталчилгааг үнэ төлбөргүй тогмтол байрлуулах | ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | Тухай бүр | Иргэдийн бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг хандлага сайжирна | Хөтөлбөрийн зардал | 2 000.0 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 6.4 | Сургуулийн эмч нар болон сургуулийн ЭМ-ийн хичээл ордог багш нарыг сургалтанд хамруулж чадавхижуулах | ЭМГ, Нэгдсэн эмнэлэг | 2022 оны эхний улиралд | Эмч багш нарын мэдлэг сайжирсанаар, өсвөр үеийн хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсрол сайжирна | Хөтөлбөрийн зардал | 2 000.0 |
| 6.5 | Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах цахим сургалт | ЭМГ | 2022 оны 1 дүгээр сард | Оролцогч 30 X 5000 дата = 150 000₮, багшийн урамшуулал 40000₮ X16ц=640 000₮ бусад зардал | Хөтөлбөрийн зардал | 1 000.0 |
| 6.6 | Иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх | ЭМБ-ууд | Жилийн турш | Иргэдийн хандлага, дадал нэмэгдэнэ. | Хөтөлбөрийн зардал | 2 000.0 |
| | НИЙТ ТӨСӨВ | | | Хандив тусламжаар | | 379 600.0 |
| | | | | ДЭМБ хөрөнгө оруулалт | | 19 500.0 |
| | | | | Орон нутгийн хөрөнгө оруулалт | | 822 204.0 |
| | | | | Засаг даргын нөөцөөс | | 300 000.0 |
| | | | | Хөтөлбөрийн зардал | | 10 000.0 |
| | | | | **ДҮН** | | **1 531 304.0₮** |

________________o0o________________